Усны төлбөр	2588.6	200.0	7.7	-2388.6
Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны	26.5	9.9	37.4	-16.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2070.8	2088.7	100.9	17.9
2. Татварын бус орлогын дүн	7195.0	7234.3	100.5	39.3
Хүү, торгуулийн орлого	4702.4	5211.9	110.8	509.5
Түрээсийн орлого	340.0	293.5	86.3	-46.5
Бусад нэр заагдаагүй орлого	197.0	298.6	151.6	101.6
Өмч хувьчлалын орлого	98.0	0.0	0.0	-98.0
Төсөвт газрын өөрийн орлого	1857.6	1430.3	77.0	-427.3
3. Тусламжийн орлого	85561.5	81354.0	95.1	-4207.5
Тусгай шилжүүлгээс санхүүжих орлого	76990.8	76249.9	99.0	-740.9
Орон нутгийн сангийн нэгдсэн шилжүүлэг	8570.7	5104.1	59.6	-3466.6

Хүснэгт 16. Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөг

	Орлогын дүн	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	зөрүү	
Багануур	1231.1	418.2	1208.1	288.9	789.9	23.0
Багахангай	783.8	1219.9	576.7	47.3	-643.2	207.1
Баянгол	6460.3	8547.8	5921.7	69.3	-2626.1	538.6
Баянзүрх	8736.3	9552.7	7656.7	80.2	-1896.0	1079.6
Налайх	2086.8	2497.3	2041.4	81.7	-455.9	45.4
Сонгинохайрхан	7574.0	8444.8	6671.1	79.0	-1773.7	902.9
Сүхбаатар	4850.0	5818.1	4840.7	83.2	-977.4	9.3
Хан-Уул	4327.8	5259.9	4311.6	82.0	-948.3	16.2
Чингэлтэй	5631.8	6479.3	5064.3	78.2	-1415.0	567.5
Нийслэлийн шууд	53032.1	86166.8	23720.6	27.5	-62446.2	29311.5
Нийт дүн	94714.0	134404.8	62012.9	46.1	-72391.9	32701.1

Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудын зардалд 134.4 тэрбум төгрөг төлөвлөснөөс 53.9 хувиар дутуу буюу нийт 62.0 тэрбум төгрөгийн санхүүжилтыг олгожээ.

Нийслэлийн төсвөөс санхүүждэг байгууллагууд сарын эхэнд 106.4 сая төгрөгийн өглөгтэй байснаас тайлант хугацаанд шинээр 216.4 сая төгрөгийн өглөг үүсч, тухайн сард 183.9 сая төгрөгийн өглөгийг төлж барагдуулан, сарын эцэст 138.9 сая төгрөгийн өглөгтэй үлдсэн байна.

Хүснэгт 17. Өглөгтэй дүүргүүд (сая.төг)

	Сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн	Тухайн сард төлөгдсөн	4-р сарын эцсийн үлдэгдэл
Багануур	78.0	7.4	5.6	79.8
Багахангай	1.6	0.0	0.0	1.6
Баянгол	1.6	204.1	176.2	29.5
Баянзүрх	2.6	0.6	0.0	3.2
Налайх	0.7	0.5	0.0	1.2
Сонгинохайрхан	1.5	0.5	1.5	0.5
Чингэлтэй	0.4	0.0	0.4	0.0
Нийслэлийн шууд	20.0	3.3	0.2	23.1
Нийт	106.4	216.4	183.9	138.9

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2013 оны эхний 4 сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 17.1 мянган байгууллагын 396.8 мянган хүн хамрагдаж шимтгэл төлсөн байна.

Нийт үйлчлүүлэгчдийн 270.8 мянга буюу 68.3 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын, 77.0 мянга буюу 20.6 хувь нь төсөвт байгууллагын, 44.2 мянга буюу 11.1 хувь нь сайн дурын даатгуулагчид байна.

Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 12.7 хувиар буюу 44.6 мянган хүнээр нэмэгджээ.


Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 115.9 хувиар биелүүлж, даатгалын санд нийт 178.8 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.5 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 19.4 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.1 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.3 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд, 1.7 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 23. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Зураг 24. Даатгалын сангийн зарлага



Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас эхний 4 сард даатгуулагч, иргэдэд 238.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон байна.

Нийт зардлын 66.9 хувийг тэтгэврийн, 17.8 хувийг эрүүл мэндийн, 8.2 хувийг ҮОМШӨ-ний, 4.7 хувийг тэтгэмжийн, 2.4 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэвэрийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 4-р сард 122.0 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 122.9 тэрбум төгрөгт хүрчээ.

Нийт олгосон тэтгэврийн 72.5 хувийг өндөр насны, 9.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.2 хувийг тэжээгчээ алдсаны, 13.5 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.

ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ


Хөдөлмөрийн яамны сар бүрийн захиргааны статистикийн мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2013 оны 4 дүгээр сарын эцэст 11755 болж, өмнөх оны мөн үеийнхээс 38.9 хувь буюу буюу 7497 хүнээр буурчээ.

Нийт ажилгүйчүүдийн 6063 буюу 51.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 19.2 хувь буюу 2263 нь 16-24 насны, 37.5 хувь буюу 4405 нь 25-34 насны, 22.9 хувь буюу 2688 нь 35-44 насны, 20.4 хувь буюу 2399 нь 45-59 насны хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 22.1 хувь буюу 2601 нь Баянзүрх, 17.4 хувь буюу 2045 нь Сүхбаатар, 14.1 хувь буюу 1655 нь Баянгол, 13.9 хувь буюу 1628 нь Чингэлтэй, 11.4 хувь буюу 1342 нь Хан-Уул, 11.2 хувь буюу 1320 нь Сонгинохайрхан, 5.3 хувь буюу 628 нь Налайх, 3.2 хувь буюу 374 нь Багануур, 1.4 хувь буюу 162 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Зураг 25. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Хүснэгт 18. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /5-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2011 он	2012 он	2013 он	2011 он	2012 он	2013 он
Нийт ажилгүйчүүд	10442	19252	11755	100	100	100
Үүнээс : дээд боловсролтой	2471	7517	4132	23.7	39.0	35.1
Тусгай дүнд боловсролтой	676	1263	987	6.5	6.6	8.4
Мэргэжлийн анхан шатны Боловсролтой	579	1356	755	5.5	7.0	6.4
Ерөнхий боловсролтой	6669	9019	5827	63.9	46.9	49.6
Мэргэжилгүй	47	97	54	0.4	0.5	0.5

2013 оны 4-р сард ажилгүй 4383 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 1921 иргэн ажилд зуучлагдан орж, 2734 иргэн бүртгэлээс хасагджээ. 2013 оны эхний 4 сард 11059 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 33.9 хувь буюу 2798 хүнээр өсчээ.

2013 оны эхний 4 сард 5549 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 2.4 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 18.0 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 79.6 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2013 оны эхний 4 сард 12966 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 1364 хүүхдээр олон байна. Нийт төрсөн хүүхдийн 14.4 хувь буюу 1862 нь бусад аймгийн харъяат эхчүүдээс төрсөн байна.

Хүснэгт 19. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл

	2011 он	2012 он	2013 он	$\frac{2013}{2012}$ %
Амаржсан эхийн тоо	9975	11534	12881	111.7
Амьд төрсөн хүүхэд	10020	11602	12966	111.8
Эхийн эндэгдэл	6	6	9	150.0
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	161	133	185	139.1
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	16.07	11.46	14.27	124.5

Нялхсын эндэгдлийн 23.2 хувь буюу 32 нь Сонгинохайрхан, 21.7 хувь буюу 30 нь Баянзүрх, 13.0 хувь буюу 18 нь Хан-Уул, 12.3 хувь буюу 17 нь Сүхбаатар, 11.6 хувь буюу 16 нь Баянгол, 10.9 хувь буюу 15 нь Чингэлтэй, 4.4 хувь буюу 6 нь Налайх, 2.9 хувь буюу 4 нь Багануур дүүрэгт тус тус гарсан байна.

Нялхсын эндэгдлийн 25.4 хувь буюу 47 нь бусад аймгийн харъяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 2.81 промилээр өсчээ.

Зураг 26. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Нийслэлд 2013 оны эхний 4 сард 6240 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 23.3 хувь буюу 1892 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 17.39 продицимилээр тус тус буурчээ.

Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 18.6 хувийг тэмбүү, 16.8 хувийг салхинцэцэг, 13.2 хувийг сүрьеэ, 12.7 хувийг гахай хавдар, 10.5 хувийг трихомониаз, 9.2 хувийг вируст гепатит, 8.9 хувийг заг хүйтэн өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Хүснэгт 20. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 4 сард

	хэмжих нэгж	2012 он	2013 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	хувиар
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	8132	6240	- 1892	- 23.3
	10000 хүнд	68.67	51.28	- 17.39	
Вируст гепатит	бодит тоо	1198	576	- 622	- 2.1 дах
	10000 хүнд	10.12	4.73	- 5.39	
Менингит	бодит тоо	6	10	4	1.7 дах
	10000 хүнд	0.05	0.08	0.03	
Цусан суулга	бодит тоо	323	247	- 76	- 23.5
	10000 хүнд	2.73	2.03	- 0.70	
Салхин цэцэг	бодит тоо	613	1048	435	1.7 дах
	10000 хүнд	5.18	8.61	3.43	
Гахай хавдар	бодит тоо	2646	795	- 1851	- 3.3 дах
	10000 хүнд	22.34	6.53	- 15.81	
Сальмонеллэз	бодит тоо	13	6	- 7	- 2.2 дах
	10000 хүнд	0.11	0.05	- 0.06	
Улаан эсэргэнэ	бодит тоо	27	71	44	2.6 дах
	10000 хүнд	0.23	0.58	0.35	
Хоолны хордлого	бодит тоо	34	33	- 1	- 2.9
	10000 хүнд	0.29	0.27	- 0.02	
Ёлом	бодит тоо	36	31	- 5	- 13.9
	10000 хүнд	0.30	0.25	- 0.05	
Улаанууд	бодит тоо	62	4	- 58	- 15.5 дах
	10000 хүнд	0.52	0.03	- 0.49	
Бруцеллэз	бодит тоо	15	4	- 11	- 3.8 дах
	10000 хүнд	0.13	0.03	- 0.10	
Гар хөл амны өвчин	бодит тоо	146	117	- 29	- 19.9
	10000 хүнд	1.23	0.96	- 0.27	
Тэмбүү	бодит тоо	818	1162	344	42.1
	10000 хүнд	6.91	9.55	2.64	
Заг хүйтэн	бодит тоо	614	554	- 60	- 9.8
	10000 хүнд	5.18	4.55	- 0.63	
Трихомониаз	бодит тоо	579	654	75	12.9
	10000 хүнд	4.89	5.37	0.48	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	839	821	- 18	- 2.1
	10000 хүнд	7.08	6.75	- 0.33	
ДОХ	бодит тоо	5	10	5	2.0 дах
	10000 хүнд	0.04	0.08	0.04	

ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Зураг 27. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар

2013 оны эхний 4 сард 5030 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15.9 хувь буюу 690 хэргээр өсчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт 52.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.6 пунктээр доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 1750 хүн гэмтэж осолдсоноос 10.3 хувь нь буюу 180 хүн нас барж, төр ард иргэдэд 29.6 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 22.9 хувь буюу 6.8 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.



Бүртгэгдсэн гэмт хэргийн 30.8 хувийг хулгайн, 25.7 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 8.6 хувийг танхайн, 7.2 хувийг залилан, 7.0 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг хэрэг, 3.9 хувийг дээрмийн хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 21. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 4 сард

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2012 он	2013 он	Тоо	Хувь
Хүний амь	52	43	- 9	- 17.3
Хүчин	45	52	7	15.6
Дээрэм	178	194	16	9.0
Хулгай	1181	1550	369	31.2
Булаалт	46	70	24	52.2
Залилан	297	361	64	21.5
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	1158	1292	134	11.6
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	339	351	12	3.5
Бусдыг амиа хорлоход хүргэх	113	182	69	61.1
Ашиглах	46	73	27	58.7
Танхайрах	424	433	9	2.1
Бусад	461	429	- 32	- 6.9
БҮГД	4340	5030	690	15.9

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 3843 болж, 2012 оны мөн үеэс 8.2 хувь буюу 292 хүнээр өссөн байна. Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 15.9 хувь буюу 613 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 25.1 хувь буюу 966 нь согтуугаар үйлдсэн, 5.0 хувь буюу 194 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ.

Сэжигтэн, яллагдагчийн 4.7 хувь буюу 182 нь хүүхэд, 16.8 хувь буюу 646 нь эмэгтэйчүүд байна.

2013 оны эхний 4 сард 22336 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.2 хувь буюу 36 хүнээр буурсан байна.

Хүснэгт 22. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, эхний 4 сард

дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2012 он	2013 он	Тоо	хувь
Багануур	108	99	- 9	- 8.3
Багахангай	6	7	1	16.7
Баянгол	880	840	- 40	- 4.5
Баянзүрх	813	1150	337	41.5
Налайх	89	107	18	20.2
Сонгинохайрхан	716	857	141	19.7
Сүхбаатар	768	824	56	7.3
Чингэлтэй	596	760	164	27.5
Хан-Уул	364	386	22	6.0
ДҮН	4340	5030	690	15.9

Хүснэгт 23. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, эхний 4 сард


дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс: ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	28	19	67.9
Багахангай	1	-	0.0
Баянгол	274	170	62.0
Баянзүрх	645	278	43.1
Налайх	19	11	57.9
Сонгинохайрхан	492	300	61.0
Сүхбаатар	442	211	47.7
Чингэлтэй	382	199	52.1
Хан-Уул	165	91	55.2
ДҮН	2448	1279	52.2

Хүснэгт 24. Бүртгэгдсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 4 сард

дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2012 он	2013 он	2012 он	2013 он
Багануур	9	24	2	18
Багахангай	2	-	2	-
Баянгол	266	199	234	164
Баянзүрх	241	394	212	330
Налайх	16	15	11	9
Сонгинохайрхан	215	332	189	280
Сүхбаатар	199	240	173	189
Чингэлтэй	132	223	99	193
Хан-Уул	101	123	91	117
ДҮН	1181	1550	1013	1300

2013 оны эхний 4 сард хүндэтгэр хэрэг 2323, хөнгөн хэрэг 2201 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17.3-21.7 хувиар өсч, онц хүнд хэрэг 106, хүнд хэрэг 400 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3.6-9.5 хувиар буурчээ.

Зураг 28. Гэмт хэргийн тоо, ангиллаар



Нийслэлийн ЗДТГ -ын дэргэдэх шуурхай мэдээллийн төвд 2013 оны эхний 4 сарын байдлаар нийт 1187 санал, гомдол ирсэн нь өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар өсчээ. Бүх санал, гомдлыг цаг тухайд нь шийдэж, барагдуулсан байна.

Зураг 29. Хүний үйл ажиллагаатай холбоотой гамшиг, ослын тоо, төрлөөр

Нийслэл хотын нутаг дэвсгэрт гарсан нийт гамшгийн тоо 174 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 дахин их байна.

Үүнээс 4 хувь буюу 7 нь ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл, 96 хувь буюу 167 нь хүний үйл ажиллагаатай холбоотой осол юм. Хүний үйл ажиллагаатай холбоотой барилгын осол 1 (0,6%), үйлдвэрийн осол 1 (0,6%), сум галт хэрэгслийн осол 2 (1,2%), тэсэрч дэлбэрэх бодисын осол 3 (1,8%), бичил уурхай, нурангины осол 5 (3%), химийн бодисын осол 22 (13.2%), бусад осол 133 (79,6%) гарсан байна.

Гамшгийн улмаас 9 хүн амь насаа алдаж, 166 хүнийг гамшгаас аварч, гамшгийн үршгийг арилгах ажилд нийт 1.1 сая төгрөг зарцуулжээ.

Нийслэл хотод 2013 оны эхний 4 сарын байдлаар нийт 985 гал түймэр гарсан нь өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар өсчээ. Төрийн өмчийн 273, хувийн өмчийн 654, аж ахуйн нэгж байгууллагын өмчийн 57, хамтын болон гадаад улсын өмчийн 1 объектод гал түймэр гарч 3.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Гал түймэрт 536 гэр, орон сууц, 357 барилга, байгууламж, тоног төхөөрөмж, 87 машин техник, 4 малын хашаа, саравч, бусад төрлийн 1 объект өртсөн байна. Гал түймрийн улмаас 18 хүн (үүнээс хүүхэд 8) амь насаа алдаж, 21 хүн (үүнээс хүүхэд 2) түлэгдэж гэмтжээ. Гал түймрийн аюулаас 393 хүн, 53 байшин барилга, 7.1 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварчээ.



Зураг 30. Гал түймэр, байршлаар



Зураг 31. Гал түймэр, гарсан шалтгаанаар



Гал түймрийн тоог дүүргээр нь авч үзвэл 22.1 хувь буюу 218 нь Баянзүрх, 20.8 хувь буюу 205 нь Сонгинохайрхан, 16.6 хувь буюу 163 нь Баянгол, 15.3 хувь буюу 151 нь Чингэлтэй, 12.5 хувь буюу 123 нь Сүхбаатар, 8.9 хувь буюу 88 нь Хан-Уул, 2.9 хувь буюу 28 нь Налайх, 0.9 хувь буюу 9 нь Багануур дүүрэгт тус тус гарсан байна.

Гал түймрийг гарсан шалтгаанаар нь авч үзвэл цахилгаанаас 183, санамсаргүй байдлаас 639, санаатай үйлдлээр 8, шалтгаан тогтоогдоогүй 123, бусад шалтгаанаар 32 гал түймэр гарсан байна.

2013 оны эхний 4 сард 22 барилгын зураг төсөл, ашиглалтанд хүлээн авч буй 47 барилгад хяналт тавьж ажиллажээ. Мөн 8423 айл өрх, 3635 объектод үзлэг шалгалт хийж, 20124 галын зөрчил илрүүлж, 132 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 790 заавал биелүүлэх албан шаардлага, 1122 мэдэгдэл хүргүүлж, 13.7 сая төгрөгийн торгууль ноогдуулсан байна.

МАЛ ТӨЛЛӨЛТ, ТӨЛ БОЙЖИЛТ

2013 оны эхний 4 сард нийслэл хотын хэмжээнд нийт хээлтэгч малын 60.3 хувь буюу 88933 хээлтэгч төллөжээ. Нийт 88961 төл гарсны 1292 төл мал хорогдож, 87669 төл бойжиж байна. Төл бойжилт 98.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна.

Хүснэгт 25. Төл бойжилт, төрлөөр, оны эхний 4 сард

	2012 он	2013 он	Үүнээс :				
			ботго	унага	тугал	хурга	ишиг
Гарсан төл	84813	88961	14	2766	11870	40917	33394
Бойжсон төл	83684	87669	14	2718	11724	40461	32752
Хорогдсон төл	1129	1292	-	48	146	456	642
Бойжилтын хувь	98.7	98.6	100.0	98.3	98.8	98.9	98.1

Хүснэгт 26. Төл бойжилт, дүүргээр, оны эхний 4 сард

дүүрэг	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Төл бойжилт
Багануур	35116	35144	629	34515	98.2
Багахангай	623	623	2	621	99.7
Баянгол	2	2	-	2	100.0
Баянзүрх	12031	12031	358	11673	97.0
Налайх	7970	7970	115	7855	98.6
Сонгинохайрхан	24631	24631	97	24534	99.6
Сүхбаатар	747	747	20	727	97.3
Хан-Уул	7492	7492	71	7421	99.1
Чингэлтэй	321	321	-	321	100.0
Дүн	88933	88961	1292	87669	98.6

Мал төллөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төллөсөн хээлтэгч 4438 толгой буюу 5.3 хувиар, бойжсон төл 3985 толгой буюу 4.8 хувиар, төл малын хорогдол 14.4 хувиар өсчээ.

Нийт бойжсон төлийн 0.02 хувийг ботго, 3.1 хувийг унага, 13.4 хувийг тугал, 46.1 хувийг хурга, 37.4 хувийг ишиг эзэлж байна.

МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

Зураг 32. Том малын зүй бус хорогдол, дүүргээр

Нийслэлийн нутаг дэвсгэрт 2013 оны эхний 4 сард 1518 толгой том мал зүй бусаар хорогдсоны 25.8 хувь буюу 392 нь өвчнөөр хорогджээ. Хорогдсон нийт малын 27.9 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

Зүй бусаар хорогдсон малын 0.1 хувийг тэмээ, 6.1 хувийг адуу, 13.9 хувийг үхэр, 39.2 хувийг хонь, 40.7 хувийг ямаа эзэлж байна.

Малын зүй бус хорогдол өмнөх оны мөн үеэс 1.5 дахин өсчээ.



Хүснэгт 27. Малын зүй бус хорогдол, дүүргээр, оны эхний 4 сард

Дүүрэг	2012 он	2013 он	Үүнээс :				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Багануур	604	1043	1	64	100	397	481
Багахангай	34	29	-	1	1	14	13
Баянзүрх	67	87	-	12	20	28	27
Налайх	82	40	-	1	14	14	11
Сонгинохайрхан	190	158	-	3	31	82	42
Сүхбаатар	11	9	-	-	4	1	4
Хан-Уул	43	148	-	12	37	59	40
Чингэлтэй	7	4	-	-	4	-	-
Дүн	1038	1518	1	93	211	595	618

ГАЗАР ТАРИАЛАН


2013 оны эхний 4 сард нийслэл хотын нутаг дэвсгэрт 84.3 га талбайд төмс, 89.2 га талбайд хүнсний ногоо тариалжээ. Хүлэмжийн нийт 14.8 га талбайд тариалалт хийсэн байна. Үүний 9.4 га талбайд өргөст хэмх, 5.4 га талбайд улаан лооль тариалжээ.

Энэ жилийн тариалалтад нийт 83.8 тонн үрийн төмс, 227.5 килограмм хүнсний ногооны үрийг хэрэглэжээ.

Хүснэгт 28. Тариалсан талбай /төрлөөр/, га

	Тариалсан талбай	Усалгаатай талбай	Хэрэглэсэн үр /кг/
Төмс	84.3	84.3	83834.8
Хүнсний ногоо	89.2	89.2	227.5
Үүнээс: байцаа	18.9	18.9	44.3
манжин	13.5	13.5	32.2
лууван	15.5	15.5	66.5
сонгино	6.9	6.9	20.1
өргөст хэмх	9.4	9.4	25.9
улаан лооль	5.4	5.4	4.4
бусад	19.6	19.6	34.1

Зураг 33. Тариалсан талбай, эхний 4 сард



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн нутаг дэвсгэрт 2013 оны эхний 4 сард байгал орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 180 тохиолдлыг илрүүлжээ. Зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар өссөн бөгөөд нийт зөрчлийн 47.2 хувийг ойн зөрчил, 28.3 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 12.8 хувийг газрын зөрчил, 8.3 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 3.4 хувийг бусад зөрчлүүд эзэлж байна. Илрүүлсэн зөрчилд 5.2 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.

Хүснэгт 29. Байгаль орчны зөрчил, төрлөөр

Илрүүлсэн зөрчил төрлөөр	2012 оны эхний 4 сар			2013 оны эхний 4 сар		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /мян.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /мян.төг/
Ой	47	39	4000.0	16	85	702.0
Ан, амьтан	-	-	-	1	1	280.8
Газрын	29	18	2175.2	28	23	2026.0
Ус	-	-	-	2	2	-
Ургамал, хөрсний бохирдол	83	81	1666.4	56	51	1451.6
Агаар, химийн хорт бодисын	31	24	1042.4	16	15	467.8
Геодези зураг зүй, кадастр	2	1	-	1	1	-
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	1	1	200.0	-	-	-
Бусад	1	1	60.0	2	2	280.8
Бүгд	194	165	9144.0	122	180	5209.0


Нийслэлийн цаг агаар 2013 оны 4 сард дунджаар 0.2⁰С байв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 2.5⁰С-аар, олон жилийн дундажтай харьцуулахад 1.9⁰С-аар хүйтэн байлаа. Энэ сард хамгийн дулаан өдөр нь 19.5⁰С, хамгийн хүйтэн өдөр нь -14.8⁰С, хур тунадасны нийлбэр 13.6 мм, салхины үнэмлэхүй их хурд 15 м/секунд хүрсэн.

Хүснэгт 30. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, 4-р сард

	Стандарт Хэмжээ	“Туул- Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		хэмжээ	бодисын хэтрэлт	хэмжээ	бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O ₂)	≥6	5.42	-	-	онцгой их бохирдсон
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ ₅)	≤ 3	2.00	-	186.0	62 дахин
Нитритийн нэгдэл (NO ₂)	≤ 0.02	0.008	-	0.503	25.2 дахин
Амоны азот (NH ₄)	≤0.5	0.174	-	45.73	91.5 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	0.023	-	2.539	25.4 дахин

Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгт бохирдуулагч бодисын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн горим алдагдаж онцгой бохирдолтой, нитридийн нэгдэл /NO₂/ 25.2 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /БХХ₅/ 62 дахин, амоны азот /NH₄/ 91.5 дахин, эрдэс фосфор /P/ 25.4 дахин хэтэрч, Туул голын ус бохирдолттой хэвээр байна.


Зураг 34. Хүхэрлэг хийн агууламж, мг/м³



Зураг 35. Азотын давхар ислийн агууламж, мг/м³



Зураг 36. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м³



Зураг 37. Тоосны /M₁₀/ агууламж, мг/м³



Хүснэгт 32. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, 4-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл экспо	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруудын ордон	Хархорин зах
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	-	0.012	0.012	0.011	0.016	-	0.009
	Хамгийн их	-	0.022	0.026	0.028	0.042	-	0.020
	XXX*-с давсан хувь	-	3.3	8.3	3.3	19.2	-	-
	Хэмжилтийн тоо	-	30	24	30	26	-	29
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	-	0.215	0.020	0.122	0.032	-	0.030
	Хамгийн их	-	0.245	0.036	0.187	0.047	-	0.047
	XXX*-с давсан хувь	-	100.0	-	100.0	16.7	-	6.9
	Хэмжилтийн тоо	-	30	24	29	24	-	29
Нүүрстөрөгчийн дутуу исэл, CO ₂ **	Дундаж	-	0.612	-	0.670	-	-	0.587
	Хамгийн их	-	3.000	-	2.500	-	-	2.538
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	90	-	90	-	-	85
Тоос PM10	Дундаж	-	0.156	-	0.108	0.181	-	0.150
	Хамгийн их	-	0.244	-	0.184	0.284	-	0.658
	XXX*-с давсан хувь	-	93.1	-	51.7	96.2	-	70.4
	Хэмжилтийн тоо	-	29	-	29	26	-	27
Тоос PM2.5	Дундаж	-	0.039	-	0.031	-	-	-
	Хамгийн их	-	0.071	-	0.071	-	-	-
	XXX*-с давсан хувь	-	20.7	-	5.0	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	29	-	20	-	-	-
Озон O ₃	Дундаж	-	-	-	0.027	0.027	-	-
	Хамгийн их	-	-	-	0.055	0.051	-	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	-	88	82	-	-

*- Хүлцэх хэм хэмжээ

**- CO₂, O₃ -ийн хэмжилтийг 8 цагийн дундаар тооцсон

Хүснэгт 31. Агаарын бохирдолт, мг/м³

Бодисын нэр	Стандарт хэмжээ	Хийсэн ажиглалтын тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдол, тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий /SO ₂ /	0.020	139	0.042	9	0.012
Азотын давхар исэл /NO ₂ /	0.040	136	0.245	65	0.084
Тоосжилт /PM ₁₀ /	0.100	111	0.658	86	0.149
Тоосжилт /PM _{2.5} /	0.050	49	0.071	7	0.035
Угаарын хий /CO ₂ /	1.5	265	3.000	-	0.623
Озон /O ₃ /	0.100	170	0.055	-	0.027

Агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийг нийслэл хотын нутаг дэвсгэрт 7 харуул цэгт хэмжихэд азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж Баруун дөрвөн замын орчимд 30 удаа, 13-р хороолол орчимд 29 удаа, 32-ын тойрог орчимд 4 удаа, Хархорин захын орчимд 2 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 32-ын тойрог орчимд 5 удаа, 1-р хороолол орчимд 2 удаа, Баруун дөрвөн зам, 13-р хороолол орчимд тус бүр 1 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруундөрвөн

замын орчимд 27 удаа, 32-ын тойрог орчимд 25 удаа, Хархорин захын орчимд 19 удаа, 13-р хороолол орчимд 15 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруундөрвөн замын орчимд 6 удаа, 13-р хороолол орчимд 1 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

Хүснэгт 33. Ус суваг ашиглалтын үйлчилгээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012 он IV сар	2013 он IV сар	2013 /2012 %
Шахсан ус	мян.м ³	18515.8	18604.1	100.5
Борлуулсан ус	мян.м ³	14474.9	14913.4	103.0
Хүн амд	мян.м ³	11034.5	11212.4	101.6
ААНБ-д	мян.м ³	3440.4	3701.0	107.6
Татан зайлуулсан бохир	мян.м ³	14204.7	14794.8	104.2
Хүн амаас	мян.м ³	10428.5	10518.6	100.9
ААНБ-аас	мян.м ³	3776.2	4276.2	113.2
Ус борлуулалтын орлого	сая төг	4927.0	5223.5	106.0
Хүн амаас	сая төг	2998.4	3143.2	104.8
ААНБ-аас	сая төг	1928.6	2080.3	107.9
Сувагжуулалтын орлого	сая төг	2765.8	2969.5	107.4
Хүн амаас	сая төг	1535.0	1548.7	100.9
ААНБ-аас	сая төг	1230.8	1420.8	115.4

НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн хүн амд 2013 оны эхний 4 сард 11.2 сая м³, аж ахуйн нэгж, байгууллагад 3.7 сая м³ цэвэр усыг борлуулжээ.

Хүн амд түгээсэн цэвэр усны 96.3 хувь буюу 10.8 сая м³-ыг нь төвлөрсөн шугамаар, 412.1 мянган м³-ыг ус түгээх байраар, 3.2 мянган м³ усыг тэвэрээр түгээсэн байна.

Цэвэрлэх байгууламжаар 18.5 сая м³ бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 14.8 сая м³ бохир шингэнийг татан зайлуулсан байна.

Энэ удаагийн дугаарыг Нийслэлийн Статистикийн газрын мэргэжилтэн Э.Зоригбат эрхлэн гаргав.